



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2019 оны 12 сарын 10 өдөр

Дугаар 514

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө олж авах зөвшөөрөл
олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8 дахь заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 3.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгийн албан ажлын хэрэгцээнд зориулан үйл ажиллагааны давсан орлогын эх үүсвэрээр 35,000,000.00 (гучин таван сая) төгрөгт багтаан 1 /нэг/ ширхэг автомашин худалдан авахыг зөвшөөрч, худалдан авах автомашины техникийн үзүүлэлт, үнийн дээд хязгаарыг хавсралтаар баталсугай.

2.Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Билгүүн, Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгийн захирал Л.Баттөр нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Үндсэн хөрөнгө худалдан авах ажлыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3.Арга хэмжээний биелэлтийг 2020 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-г үүрэг болгосугай.

ДАРГА

З.МЭНДСАЙХАН

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

А.АРИУНБОЛД

0001033

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2019 оны 12 дугаар сарын 10 ны өдрийн
074 дугаар тогтоолын хавсралт

ТӨРИЙН ТУСГАЙ АЛБАН ХААГЧДЫН НЭГДСЭН ӨМНЭЛГИЙН
ХУДАЛДАН АВАХ АВТОМАШИНЫ ТЕХНИКИЙН ҮЗҮҮЛЭЛТ,
ҮНИЙН ДЭЭД ХЯЗГААР

Д/д	Автомашины техникийн үзүүлэлт	Тоо шир хэг	Худалдаж авах хөрөнгийн үнийн дээд хязгаар (төгрөг)	
			Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	Суудлын тоо 10, хөдөлгүүрийн багтаамж 3456 cc хүртэл	1	35,000,000.00	35,000,000.00
	Нийт дүн		35,000,000.00 (гучин таван сая)	